



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2016 оны 07 сарын 18 өдөр

Дугаар 49

Мандалговь

Хөрөнгө шилжүүлэх тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 77.3 заалт, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1 заалтыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн ЗДТГазарт Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бэлтгэгдсэн 37,799,960 /гучин долоон сая долоон зуун ерэн есөн мянга есөн зуун жар/ төгрөгийн өртөгтэй Дуа 52-08 улсын дугаартай, Уаз-патриот маркын автомашиныг Говь-угтаал сумын ЗДТГазарт шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

Хоёр. Эд хөрөнгийг зохих журмын дагуу данс бүртгэлд бүртгэж авахыг Говь-угтаал сумын ЗДТГ-ын дарга Т.Урансанаад даалгасугай.

Гурав. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Дарьбумд үүрэг болгосугай.

ДАРГА

С.БУДЖАВ

0260100